



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/А03

Булган сум

Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумдад
нүүдлийн хурал зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумдад нүүдлийн хурал зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлсүгэй

2.Нүүдлийн хурлыг чанартай зохион байгуулж, тайлагнахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Сумдад ажиллахад шаардлагатай 217,120 (хоёр зуун арван долоон мянга нэг зуун хорь) төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ хэрэгжүүлэх зардлын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010980

Сугар Ажил 2025 өдөр бүр 6002142424